



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/234

Булган сум

“Оюутан цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтыг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Цэргийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсэг Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 85 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалт, Батлан хамгаалахын сайдын 2026 оны А/135 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Оюутан цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтыг 2026 оны 04 дүгээр сарын 01-ээс 08 дугаар сарын 16-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулахыг Цэргийн штаб (дэд хурандаа Т.Нямхүү)-т үүрэг болгосугай.

2. “Оюутан цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдах оюутан, суралцагчдыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах нарийн мэргэжлийн эмч нарын комисс гарган ажиллуулахыг Эрүүл мэндийн газар (Д.Нарантуяа)-т, цэргийн ерөнхий бэлтгэл сургалтын хөтөлбөрийн дагуу хичээлийн байр, техник хэрэгслээр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэбилэг)-т тус тус даалгасугай.

3. Сургалтад шаардагдах 823,000 (найман зуун хорин гурван мянга) төгрөгийг хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэбилэг)-т зөвшөөрсүгэй.

4. “Оюутан цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан 2026 оны 3 дугаар улиралд багтаан танилцуулахыг Цэргийн штаб (дэд хурандаа Т.Нямхүү)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6326010318

Аймгийн Засаг даргын 2025 оны
04 дүгээр сарын 06 ны өдрийн А/234
дугаар захирамжийн хавсралт



ЗАРЦУУЛАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

№	Зардлын чиглэл	хөрөнгийн хэмжээ	Тайлбар
1	Сургалтын материал	445,000	Дэвтэр-2ш*20ш*3000=60000 Бал 20ш*3000=60000 "Оюутан-цэрэг" сургалтын суралцагчдад зориулсан гарын авлага 10ш*30000=300,000 Хичээлийн журнал-1ш*25000=25000
2	Шатахуун	378,000	Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн сургалтын төвд хүргэж өгөх, буцааж авах
Бүгд			823,000